



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017 он

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.06.29

Чойр хот

Нэгдүгээр бүлэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Төрийн аудитын байгууллагаас 2017 онд дэвшүүлсэн **“Төрийн аудитын тогтолцооны хууль эрх зүй, бодлогын шинэтгэл, ажилтнуудын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх”** зорилтын хүрээнд Говьсүмбэр аймаг дахь Төрийн Аудитын газар нь байгууллагын үйл ажиллагаандаа **“Хариуцлага-үр дүнгийн жил”** гэсэн дэд зорилтыг дэвшүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллахад гол үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

2017 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд нийт 9 бүлэг 53 үзүүлэлтээр жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчтой үр дүнгийн гэрээ байгуулан, үйл ажиллагааны төлөвлөгөө, гэрээний үүргийн биелэлтийг хангаж, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 41 ажил төлөвлөснөөс 39 ажлыг гүйцэтгэж, төлөвлөсөн ажлыг 95.1 хувьтай хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчтой үр дүнгийн гэрээ байгуулснаар байгууллагын 3 ажилтантай үр дүнгийн гэрээ, 1 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/69 дугаар тушаалаар баталсан бүтэц, орон тооны дагуу 7 орон тоотой ажиллахаас 5 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд хүний нөөцийн 3 буюу 60 хувь нь аудитын үйл ажиллагааг гүйцэтгэж, 2 буюу 40 хувь нь удирдлага болон нийтлэг үйлчилгээний албаны ажил үүргийг гүйцэтгэж, дэвшүүлсэн зорилтыг хангаж ажиллалаа.

Тайлант хугацаанд хүний нөөцийн талаар 4, үндсэн үйл ажиллагааны талаар 13, нийт 17 тушаалыг хууль эрх зүйд нийцүүлэн гаргалаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017.02.10-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын дагуу 7 хоног тутам хийсэн ажлын тайланг мэдээлж, үүрэг даалгаврын биелэлтийг гарган, шаардлагатай асуудлыг тухай бүр шийдвэрлүүлэн, тайлант хугацаанд 21 удаагийн ажлын явцын тайланг гаргаж, ҮАГ-т цахимаар хүргүүлж ажиллалаа.

Мөн байгууллагын шуурхай хуралдааныг 7 хоног бүрийн Даваа гаригт явуулж, өмнөх 7 хоногт өгсөн үүрэг даалгаврын биелэлт, энэ 7 хоногт хийх ажлыг хэлэлцэн, хурлын тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр байгууллагын нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт хийлгэж, тамга, тэмдэгийг шинэчиллээ.

2017 оны эхний хагас жилд Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар нь санхүүгийн тайлангийн 60, гүйцэтгэлийн 6, нийцлийн 2, нийт 68 аудитыг хийж гүйцэтгэсэн бөгөөд дээрх аудитуудыг хийж гүйцэтгэхэд нийт 134/1184 хүн/өдөр зарцуулж, 3694 илүү цаг ажиллалаа.

Гүйцэтгэл, Нийцлийн нийт 8 аудитын 4 аудитыг ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар, 4 аудитыг аймгийн ИТХ-ын хүсэлтээр тус тус хийж гүйцэтгэлээ.

2017 оны эхний хагас жилийн байдлаар аудитаар нийт 13,005.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 4,847.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг аудитын явцад залруулан, 103.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд акт тогтоож, 1,312.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх 168 зөвлөмж өгч ажиллалаа.

2017 оны эхний хагас жилд хийсэн аудитын тоон үзүүлэлтийн нэгтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:


Аудитын төрөл	Аудитын тоо	Илрүүлсэн алдаа, зөрчлийн дүн / сая. төг/	Тогтоосон төлбөрийн акт /сая.төг/	Өгсөн албан шаардлага /сая.төг/	Бүртгэсэн үр өгөөж /сая.төг/	Үүнээс: Залруулсан /сая.төг/	Өгсөн зөвлөмж /тоо/
Санхүүгийн тайлангийн аудит	60	10,129.3	86.8	362.1	5,294.0	4,847.0	134
Гүйцэтгэлийн аудит	6	1,098.3	1.9	413.7	415.5		15
Нийцлийн аудит	2	1,778.2	15.1	536.2	551.4		19
ДҮН	68	13,005.8	103.8	1,312.0	6,260.9	4,847.0	168

2017 оны эхний хагас жилд нийт 103.8 сая төгрөгийн акт тогтоож, тайлант хугацаанд актын 66.0 хувь буюу 68.5 сая төгрөгийг барагдуулж ажилласан байна. Нийт тогтоосон актаас 32.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 35.7 сая төгрөгийг холбогдох байгууллагын дансанд болон хувь хүмүүст буцаан олгуулсан байна.

Тайлант хугацаанд 1,312.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгснөөс 55.8 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, албан шаардлагын хэрэгжилт 4.3 хувьтай байна.

Тайлант хугацаанд 168 зөвлөмж өгсний 28.5 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 36.9 хувийг бүртгэл, тайлагнал, 13.7 хувийг дотоод хяналтыг сайжруулах, 11.3 хувийг арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулахтай холбоотой, 9.6 хувийг бусад асуудлаар өгсөн зөвлөмж эзэлж байгаа ба нийт өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

2017 оны эхний хагас жилийн байдлаарх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг графикаар харуулбал: /сая.төг, тоо/



2017 оны эхний хагас жилийн байдлаар актын 66.0 хувь буюу 68.5 сая төгрөг, өгсөн албан шаардлагын 4.3 хувь буюу 55.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулан ажилласан ба актын 15.0 хувь, албан шаардлагын 86.9 хувийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Зөрчил гаргасан 33 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлсэнээс 15 албан тушаалтанд хариуцлага тооцож, аудитын үйл ажиллагаатай холбоотой 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажиллалаа.

2017 оны эхний хагас жилд хийсэн аудитаар 6,260.9 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж бүртгэснээр Төрийн аудитын газрын зардлын 1 төгрөгт ногдох хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 78.8 төгрөг байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн 185.0 сая төгрөгийн актын 64.6 сая буюу 35.0 хувийг барагдуулж, 4,597.0 сая төгрөгийн албан шаардлага, 108 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн тайлангийн аудитын талаар:

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчдын, улс, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөл, сангийн нийт 60 санхүүгийн тайланд аудит хийсний 70.0 хувийг төрийн аудитын байгууллага, 30.0 хувийг хувийн хэвшлийн хараат бус аудитын компаниар гэрээгээр гүйцэтгүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар 60 байгууллагад өгсөн санал дүгнэлтийн 43 буюу 71.6 хувийг зөрчилгүй, 12 буюу 20 хувийг хязгаарлалттай, 3 буюу 5 хувийг сөрөг санал дүгнэлт эзэлж, 2 буюу 3.4 хувьд дүгнэлт гаргахаас татгалзжээ.

“Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын дагуу 9 байгууллагад итгэл үзүүлж, 6 байгууллагыг түүвэрт хамруулсан бөгөөд аудитад хамрагдвал зохих санхүүгийн тайлангийн 84.6 хувийг хамруулсан байна.

Санхүүгийн аудитаар нийт 120/776 хүн/өдөр зарцуулж, нийт 2380 илүү цаг ажилласан байна. Илүү цаг ажилласан нь орон тоо хүрэлцээ муу, батлагдсан орон тооноос 2 орон тоогоор дутуу ажилласан зэргээс шалтгаалж байгаа бөгөөд 1 аудитор дунджаар 793 илүү цаг ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 10,129.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, илрүүлсэн зөрчлийн 47.9 хувь буюу 4,847.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 86.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд акт тогтоож, 362.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага өгч, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 134 зөвлөмж өгч ажиллалаа.

Тус аудитаар тогтоосон 86.8 сая төгрөгийн актын 77.3 хувь буюу 67.1 сая төгрөгийг барагдуулж, 362.1 сая төгрөгийн албан шаардлагын 15.4 хувийг хэрэгжүүлж, орон нутгийн төсөвт 31.5 сая төгрөгийг төвлөрүүллээ.

Өмнөх оноос шилжиж ирсэн 6.7 сая төгрөгийн актын 1.1 сая төгрөгийг барагдуулж, 1,843.2 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.


Тайлант хугацаанд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй бөгөөд өмнөх оноос шилжиж ирсэн зөвлөмжийн үлдэгдэлгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,294.0 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэснээр санхүүгийн тайлангийн аудитаар бий болсон Төрийн аудитын газрын зардлын 1 төгрөгт ногдох үр өгөөж 66.7 төгрөг болж байна.

Санхүүгийн тайлангийн аудитыг хийж дууссан тухай бүр аудитын тайлан, дүгнэлтийг байгууллагын удирдлагуудад гардуулан өглөө.



2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчил, шийдвэрлэлтийн судалгааг диаграмаар харуулбал:



Санхүүгийн тайлангийн аудитыг 3 аудитор гүйцэтгэж, аудитын менежер томилогдоогүйгээс аудитын чанарын хяналтыг Тэргүүлэх аудитор хэрэгжүүлэн ажилласан ба дунджаар 1 аудитор 14 аудитыг хийж гүйцэтгэлээ.

МУ-ын Ерөнхий аудиторын баталсан хуваарийн дагуу хараат бус хөндлөнгийн аудитын “Голден пейж аудит” ХХК-тай гурвалсан гэрээ байгуулж, 18 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийлгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг ангилан харуулбал:
Үүнд:

➤ НББ, тайлагналтай холбоотой	4,645.3 сая
➤ Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой	173.6 сая
➤ Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай	488.5 сая
➤ Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилттэй	525.8 сая
➤ Бусад зөрчил болон худалдан авалттай	3,511.1 сая
➤ Арвилан хэмнэлт, үр ашигтай	635.4 сая
➤ Улс, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлттэй	149.6 сая

Жил бүрийн санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийг байгууллага бүрээр болон балансын дансаар нэгтгэн мэдээллийн санг баяжуулж, байгууллага бүрээр нээсэн хувийн хэргийн өөрчлөлт, шинэчлэлтийг тухай бүр хийж ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар 22.9 сая төгрөгийн ажил, үйлчилгээний төлбөр авахаар гэрээ байгуулан ажилласанаас 6.5 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод, 16.4 сая төгрөгийг хувийн аудитын компанийн дансанд төвлөрүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай болон сөрөг санал дүгнэлт авсан, дүгнэлт өгөхөөс татгалзсан 27 албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлснээс 15 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна.

Гуравдугаар бүлэг. Гүйцэтгэлийн аудитын талаар:

2017 оны эхний хагас жилд 8 Гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөснөөс давхардсан тоогоор 32 байгууллагыг хамруулан 6 аудитыг хийж, орон тоо дутуу ажилласнаас өөрийн санаачилгаар хийж гүйцэтгэх 2 аудитын хугацаа хоцорч, аудитад нийт 10/282 хүн/ өдөр зарцуулж, 1028 илүү цаг ажиллалаа.

Тайлант хугацаанд гүйцэтгэсэн нийт 6 аудитын 3 аудитыг УАГ-ын нэгдсэн удирдамжаар, 3 аудитыг аймгийн ИТХ-ын хүсэлтээр тус тус хийж гүйцэтгэсэн ба уг аудитуудыг тодруулбал:


УАГ-ын нэгдсэн удирдамжаар:

- ✚ 2016 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр ашиг
- ✚ Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилт, үр дүн
- ✚ Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

Аймгийн ИТХ-ын захиалгаар:

- ✚ Аймгийн Цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны үр дүн
- ✚ Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын үйл ажиллагааны үр дүн
- ✚ "Тохижилт-Сүмбэр" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн

Гүйцэтгэлийн аудитаар нийт 1,098.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 1.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд акт тогтоож, 413.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага өгч, алдааг засах, дахин гаргахгүй байх 15 зөвлөмж өглөө.



Уг аудитаар нийт 415.5 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэснээр Гүйцэтгэлийн аудитаар Төрийн аудитын газрын зардлын 1 төгрөгт ногдох тооцоолсон үр өгөөж 5.2 төгрөг байна.

Гүйцэтгэлийн аудитаар тогтоосон актын 73.7 хувь буюу 1.4 сая төгрөгийг барагдуулж, зөрчил арилгуулахаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг аудит хийгдсэн хугацаанаас шалтгаалан тооцох болоогүй байна.

Гүйцэтгэлийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн ангиллыг харуулбал:

✚ Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой	13.0 сая
✚ Улс, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой	378.5 сая
✚ Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтөй холбоотой	51.1 сая
✚ НББ, тайлагналтай холбоотой	44.9 сая
✚ Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой	356.4 сая
✚ Худалдан авалттай холбоотой	254.4 сая

Гүйцэтгэлийн аудитын явцад тухайн аудиттай холбоотой байгууллагуудын удирдлага, санхүүгийн болон холбогдох ажилтнуудыг байлцуулан аудитын явцад тус байгууллагуудын хоорондын харилцаа, ажлын уялдаа, холбооноос шалтгаалан гарч буй зарим алдаа зөрчил, түүний үр дагавар, уг алдааг засаж, залруулах талаар уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, санал солилцож ажилласан нь тухайн ажил хариуцсан байгууллага, ажилтан нар өөр өөрсдийн хүлээсэн эрх үүрэг болон хийж гүйцэтгэх ажил, тухайн байгууллагуудын ажлын уялдаа холбоог ойлгуулсан үр өгөөжтөй ажил боллоо.



Гүйцэтгэлийн аудитын явцад ЯАГ-аас ирүүлсэн судалгаа, мэдээллийг бүрэн гаргаж, мөн аудитын тайлан болон бусад холбогдох материалыг цахимаар болон цаасаар цаг хугацаанд нь хүргүүлж, ЯАГ-аас зохион байгуулсан цахим хурал, сургалтанд бүрэн хамрагдлаа.

Өмнөх оноос шилжиж ирсэн Гүйцэтгэлийн аудитын актын үлдэгдэл 153.4 сая төгрөгийн 35.6 хувь буюу 54.6 сая төгрөгийг барагдуулж, 1,843.2 сая төгрөгийн албан шаардлага, 83 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн.

Дөрөвдүгээр бүлэг. Нийцлийн аудитын талаар:

2017 оны эхний хагас жилд 2 Нийцлийн аудит хийхээр төлөвлөснөөс давхардсан тоогоор 34 байгууллагыг хамруулан 2 аудитыг хийж, аудитад нийт 4/126 хүн/өдөр зарцуулж, 286 илүү цаг ажиллалаа.

Тайлант хугацаанд гүйцэтгэсэн нийт 2 аудитын 1 аудитыг ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар, 1 аудитыг аймгийн ИТХ-ын хүсэлтээр тус тус хийж гүйцэтгэсэн ба уг аудитыг тодруулбал:

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар:

- ✚ 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

Аймгийн ИТХ-ын захиалгаар:

- ✚ Халамжийн сангийн зарцуулалт, үр дүн

Нийцлийн аудитаар нийт 1,778.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн бөгөөд 15.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд акт тогтоож, 536.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага өгч, алдааг засах, дахин гаргахгүй байх 19 зөвлөмж өгч ажиллалаа.

ИЛРҮҮЛСЭН АЛДАА ЗӨРЧИЛ, ШИЙДВЭРЛЭЛТ



Уг аудитаар нийт 551.4 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж бүртгэснээр Төрийн аудитын газрын зардлын 1 төгрөгт ногдох тооцоолсон үр өгөөж 6.9 төгрөг байна.

Тайлант хугацаанд Нийцлийн аудитаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг аудит хийгдсэн хугацаанаас шалтгаалан тооцох болоогүй байна.

Нийцлийн аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийн ангиллыг харуулбал:

✚ Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтөй холбоотой	89.5 сая
✚ Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	42.2 сая
✚ НББ, тайлагналтай холбоотой	393.8 сая
✚ Дотоод хяналт хариуцлагатай холбоотой	1,003.7 сая

- ✚ Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой
- ✚ Бусад

5.0 сая
244.0 сая


Нийцлийн аудитын явцад НАГ-аас ирүүлсэн судалгаа, мэдээллийг бүрэн гаргаж, мөн аудитын тайлан болон бусад холбогдох материалыг цахимаар болон цаасаар цаг хугацаанд нь хүргүүлж ажиллахын зэрэгцээ НАГ-аас зохион байгуулсан цахим хурал, сургалтанд бүрэн хамрагдаж ажиллалаа.

Өмнөх оноос шилжиж ирсэн 24.8 сая төгрөгийн актын 8.9 сая төгрөг буюу 35.9 хувийг барагдуулж, 2,713.1 сая төгрөгийн албан шаардлагын 97.9 хувь, 25 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

***Тавдугаар бүлэг. Аймгийн ИТХ-ын хүсэлт,
өөрийн санаачлагаар хийсэн аудитын талаар:***

2017 оны эхний хагас жилд аймгийн ИТХ-ын хүсэлтээр аймгийн Цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны үр дүн, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын үйл ажиллагааны үр дүн, "Тохижилт-Сүмбэр" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүнд 3 гүйцэтгэлийн аудит, Халамжийн сангийн зарцуулалт, үр дүнд 1 нийцлийн аудит, нийт 4 аудитыг тус тус хийж гүйцэтгэлээ. Уг аудитуудад нийт 8/252 хүн/өдөр зарцуулж, 876 илүү цаг ажиллалаа.

Аудитаар нийт 1,945.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсний 1.4 сая төгрөгийн алдаа зөрчилд акт тогтоож, 387.9 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага өгч, алдаа зөрчлийг арилгах, дахин гаргахгүй байх тухай 13 зөвлөмж өглөө.



Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 2.6 хувь нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой, 19.5 хувь нь улс, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй, 63.2 хувь нь дотоод хяналт, хариуцлагатай холбоотой, 0.3 хувь нь төсвийн

төлөвлөлттэй холбоотой, 1.3 хувь нь НББ, тайлагналтай холбоотой, 13.1 хувь нь худалдан авалттай холбоотой зөрчил дутагдлууд байна.

Аймгийн ИТХ-ын хүсэлтээр гүйцэтгэсэн аудитаар нийт 389.3 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэснээр Төрийн аудитын газрын зардлын 1 төгрөгт ногдох тооцоолсон үр өгөөж 4.9 төгрөг байна.

Өөрийн санаачилгаар хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн Гүйцэтгэлийн 2 аудитыг орон тоо дутуугаас төлөвлөсөн хугацаанд аудит хийгдээгүй бөгөөд орон тоо дутуу, ажлын ачаалал их байгааг харгалзан үзэж, батлагдсан орон тоогоор бүрэн ажиллах хүртэл аудитын хугацааг хойшлуулах санал хүсэлтээ ҮАГ-т хүргүүлсэн.

Зургаадугаар бүлэг. Дотоод ажлын талаар:

Хүний нөөц: Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар нь 2017 оны эхний хагас жилд 7 орон тоо батлагдсанаас 5 орон тоотой ажилласан. Үүнээс дарга, тэргүүлэх аудитор 1, ахлах аудитор 2, аудитор 1, жолооч 1 байна. Тус байгууллагын ажилтнууд төрийн аудитын байгууллагад 7-17 жил тасралтгүй, тогтвор суурьшилтай ажиллаж байгаа бөгөөд ажилтнуудын 3 нь буюу 60.0 хувь магистрын зэрэгтэй, бүгд МНБ, дээд боловсролтой, ня-бо, эдийн засагч мэргэжилтэй байна.

Төрийн аудитын байгууллагын ажилтан албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийн Авлигын эсрэг хуулийн дагуу хугацаанд нь хүлээн авч, мэдээ тайланг ҮАГ-т хүргүүлэн, Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан.

Ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл болон хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан судалгаануудыг шинэчлэн гаргасан.

Байгууллагын дотоод журам, ажиллагсадтай байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу ажиллагсдын 2017 оны эхний хагас жилийн гэрээний биелэлт, ажлын үр дүнг дүгнэлээ.

2017 оны 3 дугаар сард ахлах аудитор Д.Оюунбат төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнууллаа. Байгууллагын 3 ахмад ажилтанг сар шинийн баяраар хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд иргэний үүргээ биелүүлэн Төрийн аудитын газрын албан хаагчид бүрэн хамрагдаж саналаа өглөө.

Сургалт, зөвлөгөөн: ҮАГ-аас зохион байгуулсан удирдах ажилтны зөвлөгөөнд дарга, тэгүүлэх аудитор, САГ-аас зохион байгуулсан СТАУС-ын сургалтанд хамт олноороо, ГАГ, НАГ-аас зохион байгуулсан 2 удаагийн онлайн сургалтанд бүрэн бүрэлдэхүүнээр хамрагдан шаардлагатай мэдээ, мэдээллийг хүлээн авч, аудитын явц, үр дүн болон тулгамдсан зарим асуудлуудын талаар тухай бүр санал солилцож, орон нутгийн шаардлагатай мэдээ мэдээлэл, судалгаа, тайланг цахимаар болон цаасаар баталгаажуулан ҮАГ-т хүргүүлж ажилласан.

2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дотоод сургалтын болон авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Орон нутгаас зохион байгуулсан 4 сургалтанд ажилтнуудыг хамруулж, байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу аудиторуудад 4 удаагийн 8 цагийн сургалтыг зохион байгууллаа.



Мэдээлэл сурталчилгаа: Байгууллагын 2016 оны үйл ажиллагааны тайланг хэвлүүлсэн. Байгууллагын мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах зорилгоор 2017 оны аудитын төлөвлөгөө, хөтөлбөр болон аудитын тайлан, цаг үеийн шинжтэй мэдээ мэдээллийг байгууллагын ил тод байдлын самбар, цахим хуудсанд тухай бүр байршуулж ажиллалаа.

2017 оны эхний хагас жилийн байдлаар Үндэсний аудитын газрын Стратеги бодлого, төлөвлөлтийн газарт 6 журмын төсөлд санал өгч, төрөлжсөн аудитын газруудад 22 мэдээ судалгааг хүргүүлсэн байна.

Өргөдөл, гомдол: 2017 оны эхний хагас жилд байгууллага болон иргэдээс аудит хийлгэх тухай нийт 4 хүсэлт, өргөдөл ирүүлсний 3 өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 1 хүсэлтийг орон нутагт шийдвэрлэх боломжгүй байсан тул ҮАГ-т хүсэлт гаргаад байна.

Бичиг хэрэг хөтлөлт, архив: 2017 оны эхний хагас жилд дарга, тэргүүлэх аудиторын А тушаал 13, Б тушаал 4 гарч, тайлант хугацаанд ирсэн 294 бичигний 26.5 хувь нь хугацаатай бичиг бөгөөд хугацаатай бичгийн хариуг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох байгууллагуудад нь тухай бүр хүргүүлж, ҮАГ болон бусад байгууллагуудад 140 бичиг, албан тоотыг гаргаж, ирсэн, явсан бичгийн бүртгэл хөтлөлт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Төрийн албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу байгууллагад хөтлөгдөх 23 нэр төрлийн архивын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргаж баталгаажууллаа.

Архивын ерөнхий газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын дагуу баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн тушаалаар баталгаажууллаа.

2017 оны эхний хагас жилд хийгдсэн аудитын болон бусад баримт материалыг архивлаж, байгууллагын архив хариуцсан ажилтанд хүлээлгэн өгч, байгууллагын статистик мэдээг шинэчлэгдсэн журмын дагуу гаргаж, ҮАГ-ын Стратеги бодлого төлөвлөтийн газарт хүргүүлээ.

Төрийн аудитын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөгдсөнөөр орон нутаг хариуцсан орлогч дарга, ажлын алба бий болж тус албанаас байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэсэн аудитуудын чанар стандартын хэрэгжилтийг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгөхийн зэрэгцээ арга зүйн зөвлөмж өглөө. Ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



Долоодугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар:

2017 оны эхний хагас жилд нийт 109.7 сая төгрөгийн урсгал үйл ажиллагааны төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 79.4 сая төгрөгийг зарцууллаа. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийн зардал нийт дүнгээрээ хэтрээгүй боловч бичиг хэрэг, шуудан холбооны зардал хүрэлцээгүйгээс төсвийг зардлын бүлэг дотор гүйлгэн зарцуулсан.

Төсвийн тухай хуульд заасны дагуу байгууллагын санхүүгийн тайланг улирал тутам, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, ҮАГ-ын орон нутгийн ажлын албанд хүргүүлэн ажиллаж байна.

2018 оны төсвийн төсөл, байгууллагын хөрөнгийн судалгаа болон бусад санхүү, төсөвтөй холбоотой мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж, ҮАГ-т хүргүүлж ажиллалаа.

2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргахтай холбоотой Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хийх бүрэлдэхүүнийг тушаалаар баталгаажуулан, хөрөнгийн тооллогыг хийж,

тооллогын үр дүнгээр актлах хөрөнгийн жагсаалтыг гарган тооллогын баримт материалын хамт ҮАГ-ын орон нутгийн ажлын албанд хүргүүллээ.

Байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Улаанбаатар Аудит корпораци” ХХК–иар аудит хийлгэж, “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, ажил гүйлгээг ҮАГ-ын шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбар, ил тод байдлын самбаруудад тогтмол байршуулж ажиллалаа.

Наймдугаар бүлэг. Дүгнэлт, ҮАГ-т уламжлах саналын талаар:

Дүгнэлт: 2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээг 95.1 хувьтай хэрэгжүүлэн ажиллалаа. Энэ нь тайлант хугацаанд өөрийн санаачилгаар хийхээр төлөвлөсөн 2 аудитыг орон тоо дутуу ажиллаж, ажлын ачаалал их, цаг хугацаа их зарцуулж, хүн хүчний хүрэлцээгүй байдлаас шалтгаалан гүйцэтгэх боломжгүй байлаа.

Орон тоо дутуу, ажлын ачаалалтай ажилласан хэдий ч дэвшүүлсэн зорилтын хүрээнд төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллахаас гадна шинэлэг байдлаар доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн нь аудитын чанар, үр өгөөжийг дээжлүүлэхэд чухал ач холбогдолтой ажил боллоо. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн болон Гүйцэтгэл, Нийцлийн аудитаар байгууллагуудын дарга, нягтлан бодогч, холбогдох ажилтнуудыг байлцуулан аудитын нээлтийг хийж, мөн аудитын тайлан, гэрчилгээг байгууллагын дарга, нягтлан бодогч нарт албан ёсоор гардуулан өгч тус аудитын үр дүн, илрүүлсэн алдаа зөрчлийн шалтгаан, үр дагавар, тэдгээрийг арилгах, өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар танилцуулж, санал солилцсон уулзалт, хэлэлцүүлгийг жил бүр зохион байгуулж, хэвшил болгож байгаа нь тухайн байгууллагын удирдлагын түвшинд алдаа зөрчлийг ойлгуулах, уг алдаа зөрчлүүдийг дахин давтан гарахгүй байх, байгууллагын удирдлагаас хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулах зэргээр олон талын ач холбогдолтой, үр дүнтэй ажил болж, үр дүнгээ өгч байна,
- Аудиторуудын гүйцэтгэж буй аудит тус бүр дээр Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг тухай бүр гаргуулан авч хэвшсэн бөгөөд 2017 онд ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байж, “Төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрмийг чандлан сахиж, мөрдөж ажиллах” тухай мэдэгдлийг оны эхэнд бүх аудиторуудаас гаргуулан авч үр дүнгийн гэрээнд хавсарган ажиллаж байна.
- Жил бүрийн санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийг байгууллага бүрээр, балансын дансдаар нэгтгэн мэдээллийн санг бүрдүүлэхийн зэрэгцээ байгууллага бүр дээр хувийн хэрэг нээн баяжилтийг тухай бүр хийж,

тухайн байгууллагын эрсдэлийг үнэлж, эрсдэлийн түвшин тогтоосны дагуу тухайн байгууллагад тусгайлан хэрэгжүүлэх горим сорилыг тодорхойлон, төлөвлөн ажиллаж байгаа нь аудитын үр өгөөжийг нэмэгдүүлэх, аудиторуудын ажлыг хөнгөвчлөх чухал ажил болж байна,

ҮАГ-т уламжлах санал, хүсэлт:

- Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх СТАУС-2 програмыг сайжруулах, дутуу, хийгдэх шаардлагатай ажлуудыг 2018 оны Санхүүгийн тайлангийн аудитаас өмнө дуусгах, ажилбаруудын уялдаа холбоог сайжруулах, бүх ажлыг програмын ажлын талбар дээр хийж гүйцэтгэдэг болгох,
- Орон тоо дутуу ажилласнаас аудиторуудын ажлын ачаалал маш өндөр, цаг хугацаа их зарцуулах, аудитыг багаар гүйцэтгэх боломжгүйгээс аудитын стандарт зөрчигдөж байна. Бүх аудитыг 3 аудитор гүйцэтгэж байгаа бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын хугацаатай давхцаж гүйцэтгэл, нийцлийн аудитууд хийгдэж байгаа нь аудитын чанар үр өгөөжид сөргөөр нөлөөлөхөөс гадна аудиторуудын эрүүл ахуйн нөхцөл, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Иймд дутуу ажиллаж байгаа 2 орон тооны асуудлыг шийдвэрлэх
- Орон тоо дутуу ажилласнаас 2017 оны эхний хагас жилд төлөвлөсөн 2 аудитын хугацаа хоцорсон тул аудитын хугацааг хойшлуулах хүсэлтийг орон нутаг хариуцсан орлогч даргад хүргүүлснийг шийдвэрлэх
- 2015, 2016 онд аудитын мэргэшлийн шалгалтыг амжилттай өгсөн 3 ажилтны аудитын мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хувийг МУЕА-ын 2015.06.18-ны өдрийн 160 дугаар тушаалаар баталсан журмын дагуу нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэх
- Боловсон хүчний мэдлэг, мэргэжлийн түвшинг дээшлүүлэх, ажлын туршлага эзэмшүүлэх зорилгоор орон нутаг дахь Төрийн аудитын газрын ажилтнуудыг ҮАГ-аас зохион байгуулж буй гадаад сургалтууд болон ЭСЯ-ыг шалгах аудитад оролцуулах. /аудиторууд гадаад сургалтанд огт хамрагдаж байгаагүй/
- Байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор төрийн аудитын байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй, тасралтгүй ажиллаж байгаа ажилтнуудыг шат дараалалтайгаар орон сууцны дэмжлэгт хамруулах

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.САРАНТУЯА